

ТУСГАЙ ЦЭЦЭРЛЭГИЙН **ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ** ХҮҮХДИЙН ЧАДВАРЫГ ИЛРҮҮЛЭХ
ДААЛГАВАР


Багшийн нэр:

2024 он ... сар ... өдөр

Хүүхдийн нэр:

Бэрхшээлийн онцлог:

Даалгавар: 1 ХА-1	Сургалтын чиглэл: Танин мэдэхүй
Илрүүлэх чадвар: Юмсыг хэмжээгээр нь ялгах	
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Хүүхдийн гүйцэтгэлээр	

Даалгавар	Хэмжээгээрээ ялгаатай 3-5 ширхэг дугуй дүрсийг томоос жижиг дарааллаар суварганд хийнэ.		
Хэрэглэгдэхүүн	Томоосоо жижиг дараалалтай 5 ширхэгтэй дугуй дүрс бүхий суварган тоглоом		
Даалгаврын заавар	Дүрсийг тэмтэрч үзээд том дугуй дүрснээс нь эхлээд суварганы голд хийнэ. Дараагийн дүрсийг өмнөхөөс жижиг дүрс сонгох хэлбэрээр томоос жижиг рүү нь дараалуулан хийнэ.		
Даалгавар явуулах аргачлал	Багшийн хэлэх үг	Багшийн хийх үйлдэл	
	<p>Багш тоглоомыг задлахын өмнө хүүхдэд бариулж, тэмтэрч мэдрүүлнэ. Дараа нь багш том жижиг дугуй дүрсийг хольж тавьсан байна.</p> <ul style="list-style-type: none"> - Дүрс хийх суварганы голыг тэмтэрч урдаа тавиарай. - Суварган тоглоомоо байрлуулахдаа хамгийн том дугуй дүрсийг хамгийн доор нь, байрлуулах ба хэмжээг томоос жижиг рүү дээр дээрээс нь давхарлан хамгийн жижиг дугуй дүрс хамгийн дээр байрлуулна. - Бүх дүрсийг тэмтэрч үзээрэй. - Хамгийн том дугуй дүрсийг тэмтэрч олоорой. - Том дугуй дүрсээ суварганы голд хийгээрэй. - Дараагийн том дугуй дүрсийг олоорой. - Олсон дүрсээ суварганы голд хийгээрэй гэх мэтчилэн дугуй дүрсүүдийг суварганы голд хийнэ. - Багш дасгалын төгсгөлд багштай хамт тоглосон чамд баярлалаа. Чи сайн байлаа, чамд баяр хүргэе гэж хэлээд алга ташна. 		 <p>Суварган тоглоомыг задлан тавина.</p>
Даалгавар №1 үнэлгээ	№	Хариултын хувилбар	Тохирох тэмдэглэл
	1	Бүх суварган тоглоомыг зөв хийж гүйцэтгэсэн.	5
	2	3-4 суварган тоглоомыг томоос жижиг рүү дарааллаар байрлуулсан.	4
	3	1-2 суварган тоглоомыг томоос жижиг рүү дарааллаар байрлуулсан.	3
	4	Суварган тоглоомуудыг байрлал буруу ч сууринд 1-2 ширхэг тоглоомыг байрлуулсан.	2
	5	Суварган тоглоомыг байрлуулахаар оролдсон	1
	6	Хүүхэд даалгавар гүйцэтгэх оролдлого хийхгүй, татгалзсан.	0
Дэмжлэг	Хүүхдийн анхаарал сарнихгүй тав тухтай байдлыг хангана. Хүүхдийг бэлэн болтол хүлээнэ.		
Анхаарах зүйл	Хүүхэд юу хийх талаар багш ойлгомжтой тайлбарлана. Хүүхэд үйлдийг нэг удаа хийнэ. Хэрвээ хүүхэд томоос жижиг руу хийхээ мэдэхгүй бол дахин хийлгэх шаардлагагүй. Суварганы гол болон дугуй дүрсийг хүүхдийн гарт ойр байрлуулна.		

ТУСГАЙ ЦЭЦЭРЛЭГИЙН **ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ** ХҮҮХДИЙН ЧАДВАРЫГ ИЛРҮҮЛЭХ
ДААЛГАВАР

Багшийн нэр:
Хүүхдийн нэр:

2024 он ... сар ... өдөр
Бэрхшээлийн онцлог:

Даалгавар: 2 ХА-2	Сургалтын чиглэл: Танин мэдэхүй
Илрүүлэх чадвар: Эд юмсыг тэмтэрч нэрлэх, ангилах	
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Хүүхдийн гүйцэтгэлээр	

Даалгавар	Юмсыг тэмтэрч нэрлээрэй. Жижиг бөглөө, том жижиг чулуу, жижиг машин зэргийг бүлэглэж нэрлэнэ.			
Хэрэглэгдэхүүн	Сагс 3 ширхэг, бөглөө 3 ширхэг, жижиг машин 3 ширхэг, чулуу 3 ширхэг			
Даалгаврын заавар	Даалгаварт ашиглах зүйлсийг урьдчилан бэлтгэсэн байна. 9 ширхэг зүйлсийг хүүхдийн урд хольж тавина. Урд байгаа зүйлээ тэмтэрч мэдрээд юу байгааг нэрлэж хэлээд ижил ижлээр нь сагсанд хийж ангилаарай.			
Даалгаврыг явуулах аргачлал	Багшийн хэлэх үг		Багшийн хийх үйлдэл	
	Багш нь чиний урд 9 ширхэг тоглоом, эд зүйл, 3 ширхэг сагс тавьсан байна. Чи эд зүйлсийг тэмтэрч мэдрээд, юу болохыг нэрлэж хэлнэ. Дараа нь 3 сагсанд ижлээр нь ангилан хийгээрэй.		Багш хүүхдийн хариулт, үйлдлийг бичиж тэмдэглэнэ.	
Даалгавар №2 үнэлгээ	№	Хариултын хувилбар		Тохирох тэмдэглэл
	1	Тоглоом эд зүйлсийг зөв нэрлэж, 3 сагсанд 9 зүйлсийг зөв ангилж ялгасан.		5
	2	Тоглоом эд зүйлсийг зөв нэрлэж, 3 сагсанд 7-8 зүйлсийг зөв ангилж ялгасан.		4
	3	2 зүйлийг зөв нэрлэж, 3 сагсанд 4-6 зүйлсийг зөв ангилж ялгасан.		3
	4	1 зүйлийг зөв нэрлэж, 3 сагсанд 1-3 зүйлсийг зөв ангилж ялгасан.		2
	5	Тоглоомыг нэрлэхийг оролдож, эд зүйлсийг сагснуудад хольж хийсэн.		1
6	Хүүхэд даалгавар гүйцэтгэх оролдлого хийхгүй, татгалзсан.		0	
Дэмжлэг	Хүүхдээр нэрлүүлэх зүйлсийг хүүхдийн гарт ойрхон байрлуулна.			
Анхаарах зүйл	Хэрэглэгдэхүүнийг бэлтгэсэн байна. Хэрэглэгдэхүүнийг ам, хамартаа хийхгүй байхыг сануулж хэлнэ.			

ТУСГАЙ ЦЭЦЭРЛЭГИЙН **ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ** ХҮҮХДИЙН ЧАДВАРЫГ ИЛРҮҮЛЭХ
ДААЛГАВАР

Багшийн нэр:
Хүүхдийн нэр:

2024 он ... сар ... өдөр
Бэрхшээлийн онцлог:

Даалгавар: 3 ХА-3	Сургалтын чиглэл: Хөдөлгөөн
Илрүүлэх чадвар: Дасгал хөдөлгөөнийг дарааллын дагуу хийх	
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Хүүхдийн гүйцэтгэлээр	

Даалгавар	Өглөөний дасгалыг багшийн заавраар хийнэ.		
Хэрэглэгдэхүүн	Чөлөөтэй орон зай, хувцас		
Даалгаврын заавар	Даалгаврын гүйцэтгэлийг багш 1 удаа хүүхэдтэй хамтран хийнэ. Дараа нь хүүхэд багшийн заавраар 2 удаа хийнэ. Багшийн зааврын дагуу дасгал хөдөлгөөнийг хийнэ.		
Даалгаврыг явуулах аргачлал	Багшийн хэлэх үг		Багшийн хийх үйлдэл
	<ul style="list-style-type: none"> - Өглөөний дасгалаа хийцгээе. - Багшийнхаа хэлж байгааг анхааралтай сонсоорой. Дасгал эхэллээ биеэ цэхлэн анхаарлаа төвлөрүүлээрэй. Дасгал 1: <ul style="list-style-type: none"> - 2 гараа дээшээ өргөөрэй. Дасгал 2: <ul style="list-style-type: none"> - 2 гараа мөрөндөө хүргээрэй. Дасгал 3: <ul style="list-style-type: none"> - 2 гараа алдлаарай. Дасгал 4: <ul style="list-style-type: none"> - 2 гараа буулгаарай. Багш дасгалын төгсгөлд багштай хамт тоглосон чамд баярлалаа. Чи сайн байлаа, чамд баяр хүргэе гэж хэлээд алга ташна.		-Багш хүүхдийн гарыг бариад дасгалыг 1 удаа тоолж давтан хийлгэнэ.
Даалгавар №3 үнэлгээ	№	Хариултын хувилбар	Тохирох тэмдэглэл
	1	Бүх дасгалыг 2 удаа алдалгүй бие даан зөв гүйцэтгэсэн.	5
	2	3 дасгалыг зөв хийж гүйцэтгэсэн, аль нэг дасгалыг буруу хийсэн.	4
	3	2 дасгалыг зөв хийж гүйцэтгэсэн, 2 дасгалыг буруу хийсэн.	3
	4	Алдаа гаргасан ч дасгалыг өөрийнхөөрөө хийж дуусгасан.	2
	5	Дасгалыг гүйцэтгэхийг оролдож, гараа хөдөлгөх үйлдэл хийсэн.	1
	6	Хүүхэд даалгавар гүйцэтгэх оролдлого хийхгүй, татгалзсан.	0
Дэмжлэг	Багш дасгалыг хийхдээ хүүхдийн гарыг барьж хийж үзүүлнэ. Дасгалыг хийлгэх явцдаа дасгалын дарааллыг алдуулахгүй байна.		
Анхаарах зүйл	Хүүхдийн осол аюулгүй байдлыг хангана. Багшийн заавар ойлгомжтой чанга тод байна. Хөгжмийн ая ашиглахгүй.		

ТУСГАЙ ЦЭЦЭРЛЭГИЙН **ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ** ХҮҮХДИЙН ЧАДВАРЫГ ИЛРҮҮЛЭХ
ДААЛГАВАР

Багшийн нэр:
Хүүхдийн нэр:

2024 он ... сар ... өдөр
Бэрхшээлийн онцлог:

Даалгавар: 4 ХА-4	Сургалтын чиглэл: Танин мэдэхүй
Илрүүлэх чадвар: Гарын жижиг булчингийн хөгжил, мэдрэмж, эвсэл	
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Хүүхдийн гүйцэтгэлээр	

Даалгавар	Савны таг эргэдэж онгойлгоно, таглана.		
Хэрэглэгдэхүүн	Янз хэмжээтэй эргэдэж онгойдог тагтай өөр өөр савнууд 5 ширхэг		
Даалгаврын заавар	Янз бүрийн хэмжээтэй эргэдэж онгойдог тагтай савнуудын таглааг онгойлгож, таглана. Тагласан саваа сагсанд хийнэ.		
Даалгаврыг явуулах аргачлал	Багшийн хэлэх үг		Багшийн хийх үйлдэл
	<ul style="list-style-type: none"> - Багш нь ширээн дээр эргэдэж онгойдог тагтай савнууд тавьсан байгаа 1 савыг сонгон аваарай. - Авсан савныхаа таглааг эргэдэж онгойлгоорой. - Таглааг нь онгойлгосон саваа буцаагаад таглаарай. - Багш дасгалын төгсгөлд багштайгаа хамт тоглосон чамд баярлалаа. Чи сайн байлаа, чамд баяр хүргэе гээд алга ташна. 		Эргэдэж онгойдог тагтай өөр хоорондоо адилгүй хэлбэр, хэмжээтэй 5 ширхэг сав бэлтгэнэ.
Даалгавар №4 үнэлгээ	№	Хариултын хувилбар	Тохирох тэмдэглэл
	1	5 савны таглааг эргэдэж онгойлгоод буцаан таглах үйлдлийг бүрэн хийсэн.	5
	2	4-н савны таглааг эргэдэж онгойлгоод, 1-4 таглааг буцаан тагласан.	4
	3	5 савнуудын таглааг зөвхөн эргэдэж онгойлгосон.	3
	4	1-3 таглааг эргэдэж онгойлгосон.	2
	5	Таглааг онгойлгох оролдлого хийсэн.	1
6	Хүүхэд даалгавар гүйцэтгэх оролдлого хийхгүй, татгалзсан.	0	
Дэмжлэг	Даалгаврыг гүйцэтгэж эхлэхээс өмнө хүүхдэд дэмжлэг үзүүлж нэг савны таглааг онгойлгож, буцаан таглах үйлдлийг хамтдаа хийнэ.		
Анхаарах зүйл	Хүүхдийн аюулгүй байдлыг хангана. Таглааг хэтэрхий чанга тагласан эсэхийг шалгана.		

ТУСГАЙ ЦЭЦЭРЛЭГИЙН **СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ** ХҮҮХДИЙН ЧАДВАРЫГ ИЛРҮҮЛЭХ
ДААЛГАВАР

Багшийн нэр:
Хүүхдийн нэр:

2024 он ... сар ... өдөр
Бэрхшээлийн онцлог:

Даалгавар: 5 СО-1	Сургалтын чиглэл: Танин мэдэхүй
Илрүүлэх чадвар: Өөрийн хэрэгцээг илэрхийлсэн дохиог дагаж илэрхийлэх	
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Хүүхдийн гүйцэтгэлээр	

Даалгавар	Багшийн дохиж байгааг дуурайж үзүүлэх		
Хэрэглэгдэхүүн	Зурагт үзүүлэн 4 ширхэг		
Даалгаврын заавар	Зурагт үзүүлэнгүүдийг харуулаад асуулт асууна. Хүүхдэд дохиогоор илэрхийлээрэй гэсэн зааврыг хэлнэ.		
Даалгавар явуулах аргачлал	Багшийн хэлэх үг		Багшийн хийх үйлдэл
	<ol style="list-style-type: none"> 1. Дараах 4 зураг тус бүрийг үзүүлээд хүүхэд юу хийж байгааг асууж хүүхдээс дохиогоор хариулт авна. 2. Хүүхдээс юу хүсэж байгааг асууна. <ol style="list-style-type: none"> a. Чи ном үзмээр байна уу? дохиогоор хариулаарай. b. Чи ус уумаар байна уу? дохиогоор хариулаарай. c. Чи унтмаар байна уу? дохиогоор хариулаарай. d. Чи бие засмаар байна уу? дохиогоор хариулаарай. 		Зурагт үзүүлэн хүүхдэд үзүүлээд хүүхдийн үйл хөдөлгөөн илэрхийллийг анхааралтай ажиглана.
Даалгавар №5 үнэлгээ	№	Хариултын хувилбар	Тохирох тэмдэглэл
	1	Бүх зурагт үзүүлэнг үйлдлээр илэрхийлсэн, мөн өөрийн байдлыг тус бүрд хариулж дохиогоор илэрхийлсэн.	5
	2	3 зурагт үзүүлэнг үйлдлээр илэрхийлсэн, мөн өөрийн байдлыг асуусан 3 асуултад хариулж дохиогоор илэрхийлсэн.	4
	3	2 зурагт үзүүлэнг үйлдлээр илэрхийлсэн, мөн өөрийн байдлыг асуусан 2 асуултад хариулж дохиогоор илэрхийлсэн.	3
	4	1 зурагт үзүүлэнг үйлдлээр илэрхийлсэн, мөн өөрийн байдлыг асуусан 1 асуултад хариулж дохиогоор илэрхийлсэн.	2
	5	Багшийн асуултад хариулах оролдлого хийсэн.	1
	6	Хүүхэд даалгавар гүйцэтгэх оролдлого хийхгүй, татгалзсан.	0
Дэмжлэг	Асуултыг 2-3 удаа давтан асууна.		
Анхаарах зүйл	Дасгал гүйцэтгэх зааврыг дохионы хэлээр сайн тайлбарлаж өгөх.		

Даалгавар: 5-д ашиглах зураг



ТУСГАЙ ЦЭЦЭРЛЭГИЙН **СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ** ХҮҮХДИЙН ЧАДВАРЫГ ИЛРҮҮЛЭХ
ДААЛГАВАР

Багшийн нэр:
Хүүхдийн нэр:

2024 он ... сар ... өдөр
Бэрхшээлийн онцлог:

Даалгавар: 6 СО- 2	Сургалтын чиглэл: Танин мэдэхүй
Илрүүлэх чадвар: Өнгө ялгах	
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Хүүхдийн гүйцэтгэлээр	

Даалгавар	Өнгийн цаасан бөмбөгийг тохирсон өнгөтэй аяганд хийх		
Хэрэглэгдэхүүн	Гурван төрлийн өнгөтэй аяга улаан, шар, цэнхэр Өнгө тус бүрээс 4 ширхэг цаасан бөмбөг нийт 12 ширхэг, 1 удаагийн таваг 1 ширхэг		
Даалгаврын заавар	<ol style="list-style-type: none"> 1. Гурван төрлийн өнгөтэй аяга хүүхдийн урд байрлуулна. 2. Таваганд 3 өнгийн цаасан бөмбөгийг хийж байрлуулна. 3. Өнгийн аяганд тохирсон өнгөтэй цаасан бөмбөгийг олж хийгээрэй гэсэн заавар өгнө. 4. Өнгийг дохиогоор нэрлүүлнэ. 		
Даалгавар явуулах аргачлал	Багшийн хэлэх үг	Багшийн хийх үйлдэл	
	<ol style="list-style-type: none"> 1. Чиний урд гурван өөр өнгөтэй аяга байна. Бас цаасан бөмбөгнүүд байна. 2. Улаан өнгөтэй аяганд улаан цаасан бөмбөгнүүдийг авч хийгээрэй. 3. Энэ ямар өнгөтэй аяга вэ? Энэ ямар өнгөтэй бөмбөг вэ? гэж хүүхдээс асууж бататгана. 4. Бусад өнгийг мөн адил асууж даалгаврыг гүйцэтгэнэ. <p>Багш дасгалын төгсгөлд багштай хамт тоглосон чамд баярлалаа. Чи сайн байлаа, чамд баяр хүргэе гэж хэлээд алга ташна.</p>	<p>Гурван өнгийн аяга, өнгө тус бүрээс 4 ширхэг нийт 12 ширхэг цаасан бөмбөг бэлдэнэ.</p> <p>Тохирсон аяганд ижил өнгийн цаасан бөмбөг сонгож хийх заавар өгнө.</p> <p>Ямар өнгөтэй аяга болон цаасан бөмбөг болохыг асууж ярилцана.</p>	
Даалгавар №6 үнэлгээ	№	Хариултын хувилбар	Тохирох тэмдэглэл
	1	Бүх бөмбөгийг аягануудад зөв байрлуулж хийсэн мөн 3 өнгийг дохиогоор зөв нэрлэж үзүүлсэн.	5
	2	Бүх бөмбөгийг аягануудад зөв байрлуулж хийсэн мөн 1-2 өнгийг дохиогоор зөв нэрлэж үзүүлсэн.	4
	3	Бүх бөмбөгийг аягануудад зөв байрлуулж хийсэн ч өнгөнүүдийг дохиогоор нэрлэж илэрхийлээгүй.	3
	4	Бөмбөгнүүдийн өнгийг хооронд нь хольж аягануудад хийсэн, өнгөнүүдийг дохиогоор нэрлэж илэрхийлээгүй.	2
	5	Бөмбөгнүүдээс авч аяганд хийх оролдлого хийсэн.	1
	6	Хүүхэд даалгавар гүйцэтгэх оролдлого хийхгүй, татгалзсан.	0
Дэмжлэг	Тохирох өнгө сонгож чадахгүй бол дэмжлэг үзүүлнэ. Мөн өнгийг дохионы хэлээр илэрхийлж чадахгүй бол нэг удаа тусална.		
Анхаарах зүйл	Улаан, шар, хөх (цэнхэр) өнгийн спорт өрөлтийн аягыг ашиглаж болно. Хэрвээ тийм аяга байхгүй бол үнэлгээний багийн гишүүд нэг удаагийн цаасан аягыг өнгийн гуашаар будах, өнгийн цаас наах гэх мэтээр бэлтгэсэн байна. Өнгийн цаасыг базаж бөөрөнхийлөн цаасан бөмбөлгүүдийг хийж бэлтгэнэ.		

ТУСГАЙ ЦЭЦЭРЛЭГИЙН **СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ** ХҮҮХДИЙН ЧАДВАРЫГ ИЛРҮҮЛЭХ
ДААЛГАВАР

Багшийн нэр:
Хүүхдийн нэр:

2024 он ... сар ... өдөр
Бэрхшээлийн онцлог:

Даалгавар: 7 СО-3	Сургалтын чиглэл: Танин мэдэхүй
Илрүүлэх чадвар: Өнгө ялгах болон байрлал тогтоох	
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа Хүүхдийн гүйцэтгэлээр	

Даалгавар	5 шилтэй усанд 5 өнгийн будаг дусааж хутгаад дараалуулж тавина. Өнгийн дарааллаар нь тогтоох, байрлалыг солиод хэсэг хугацааны дараа дарааллын дагуу зөв байрлуулах, өнгийг таних																			
Хэрэглэгдэхүүн	5 өнгийн будаг, шилтэй ус, 5 ширхэг харандаа, жижиг халбага, алчуур																			
Даалгаврын заавар	<ol style="list-style-type: none"> Багш устай шилэн саван дотор өнгийн будаг хийж, хүүхэд халбагаар өнгийг хутгаж усны өнгийг ажиглана. Өнгө өнгийн устай шилэн савыг эгнүүлэн тавьж хүүхдээр 15 секунд ажиглуулна. Дараа нь шилэн савны дээр алчуур тавьж хаахад хүүхэд өөртөө байгаа 5 ширхэг харандааг авч ажигласан усны шилэн савтай ижил байрлалд оруулна. Зөв байрлуулсан эсэхийг шалгаад дахин алчуураар бүтээгээд багш 2 устай савны байрлалыг сольж тавина. Ямар өнгийн устай савны байрлал солигдсон бэ? гэж асууна. Багш хүүхэдтэй нэг удаа тоглож үзүүлнэ. 																			
Даалгаврыг явуулах аргачлал	Багшийн хэлэх үг	Багшийн хийх үйлдэл																		
	<ol style="list-style-type: none"> Ямар өнгийн устай шилэн сав хаана байгааг сайн ажиглаарай гэж хэлээд багш амандаа 15 хүртэл тоолно. За багш нь устай саван дээр алчуур тавилаа. Одоо багшийнхаа өгсөн харандааг авч ажигласан дарааллын дагуу өнгөөр нь байрлуулаарай. За одоо алчуураа аваад зөв бурууг харцгаая гэж хэлнэ. Багш дахин алчуураа тавиад 1 устай савны байрлалыг сольж хүүхдээр ажиглуулна. Энэ мэт 5 удаа тоглоно. Багш дасгалын төгсгөлд багштайгаа хамт тоглосон чамд баярлалаа. Чи сайн байлаа, чамд баяр хүргэе гээд алга ташна. 	<p>Савтай усанд өнгийн будаг хийгээд хүүхдэд халбага өгч усыг хутган өнгөнд оруулж хамтран тоглоно. Хүүхдийг савтай усны өнгөний дарааллыг анхааралтай ажиглахыг хүснэ. Хүүхдэд хугацаа олгоно. Багш алчуурыг сөхөөд устай савны байрлалыг өөрчилнэ. Хүүхдийн даалгаврын гүйцэтгэлийг ажиглахдаа доор хүснэгтэд тэмдэглэл хийж түүндээ үндэслэн хариултын хувилбараас тохирох оноог сонгоно. Багш болон үнэлгээний баг байрлалыг зөв олсон эсэхийг тэмдэглэнэ.</p> <table border="1"> <thead> <tr> <th></th> <th>Зөв</th> <th>Буруу</th> </tr> </thead> <tbody> <tr><td>1</td><td></td><td></td></tr> <tr><td>2</td><td></td><td></td></tr> <tr><td>3</td><td></td><td></td></tr> <tr><td>4</td><td></td><td></td></tr> <tr><td>5</td><td></td><td></td></tr> </tbody> </table>			Зөв	Буруу	1			2			3			4			5	
	Зөв	Буруу																		
1																				
2																				
3																				
4																				
5																				
Даалгавар №7 үнэлгээ	№	Хариултын хувилбар	Тохирох тэмдэглэл																	
	1	Бүх даалгаврыг бие даан зөв гүйцэтгэсэн бол	5																	
	2	3-4 харандааны өнгийг зөв байрлуулж тавьсан, байрлалыг сольсон савтай усыг 3-4 удаа зөв олж нэрлэсэн.	4																	
	3	1-2 харандааны өнгийг зөв байрлуулж тавьсан, байрлалыг сольсон савтай усыг 1-2 удаа зөв олж нэрлэсэн.	3																	
	4	Харандаануудыг эгнүүлэн өрж тавьсан бол	2																	
	5	Харандааг барьж даалгаврыг гүйцэтгэх оролдлого хийсэн.	1																	
6	Хүүхэд даалгавар гүйцэтгэх оролдлого хийхгүй, татгалзсан.	0																		
Дэмжлэг	Даалгаврыг эхлэхээс өмнө багш өөрөө биечлэн нэг удаа хийж үзүүлнэ.																			
Анхаарах зүйл	<ul style="list-style-type: none"> Хүүхдийн анхаарал сарнихгүй орчинг бүрдүүлнэ. Даалгавар гүйцэтгэх зааврыг дохионы хэлээр сайн тайлбарлаж өгнө. 																			

ТУСГАЙ ЦЭЦЭРЛЭГИЙН **СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ** ХҮҮХДИЙН ЧАДВАРЫГ ИЛРҮҮЛЭХ
ДААЛГАВАР

Багшийн нэр:
Хүүхдийн нэр:

2024 он ... сар ... өдөр

Бэрхшээлийн онцлог:.....

Даалгавар: 8 СО-4	Сургалтын чиглэл: Хөдөлгөөн
Илрүүлэх чадвар: Тэнцвэр болон танин мэдэхүйн чадвар	
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Хүүхдийн гүйцэтгэлээр	

Даалгавар	Аягатай бөмбөг барьж, зураасны дагуу тэнцвэрээ хадгалан алхан 5 метр зайд байрлах сагсанд бөмбөгөө хийгээд аягаа барин буцаж ирнэ.		
Хэрэглэгдэхүүн	Нэг удаагийн цаасан аяга эсвэл спорт өрөлтийн аяга 3 ширхэг, аяганы амсарт таарах улаан, цэнхэр, шар бөмбөг, бөмбөгтэй ижил өнгөтэй сагс эсвэл хайрцаг, шулуун зураас		
Даалгаврын заавар	1. Аягатай бөмбөгийг барин зураасны дагуу алхана 2. Бөмбөгтэй ижил өнгийн сагс, хайрцагийг олж бөмбөгөө хийнэ 3. Аягаа барин буцаж зураасны дагуу алхаж ирнэ.		
Даалгавар явуулах аргачлал	Багшийн хэлэх үг	Багшийн хийх үйлдэл	
	1. Газраас улаан өнгийн бөмбөгтэй аягыг аваарай. 2. Одоо энэ шулуун зураасан дээгүүр алхаарай. 3. Алхаж явахдаа бөмбөгөө унагаахгүйг анхаараарай. 4. Улаан өнгийн сагсыг олж аягаа тонгойлгон бөмбөгөө хийгээрэй. 5. Аягаа бариад буцаад зураасны дагуу алхаарай г.м үргэлжлүүлнэ. 6. Багш дасгалын төгсгөлд багштайгаа хамт тоглосон чамд баярлалаа. Чи сайн байлаа, чамд баяр хүргэе гээд алга ташна.	Зураасан дээгүүр тэнцвэртэй алхаж байгаа болон бөмбөгийг зөв сагсанд хийхэд нь урамшуулна.	
Даалгавар №8 үнэлгээ	№	Хариултын хувилбар	Тохирох тэмдэглэл
	1	Бөмбөгөө унагалгүй, шулуун зураасны дагуу алхаж, бөмбөгөө ижил өнгөтэй сагсанд хийхдээ бусдын тусламжгүй даалгаврыг гүйцэтгэсэн.	5
	2	Шулуун зураасан дээгүүр алхахдаа зурааснаас 2- 3 удаа гарч тэнцвэрээ алдсан, багшаас дэмжлэг хүссэн, бусдыг сайн гүйцэтгэсэн.	4
	3	3 бөмбөгнөөс бусад даалгаврыг сайн гүйцэтгэсэн.	3
	4	Бүх даалгавраас 4-ыг багшийн дэмжлэг, заавартай гүйцэтгэсэн.	2
	5	Даалгаврыг гүйцэтгэх оролдлого хийсэн бол	1
6	Хүүхэд даалгавар гүйцэтгэх оролдлого хийхгүй, татгалзсан.	0	
Дэмжлэг	Зурааснаас гарах болон хүүхдийн хүсэлтээр дахин алхуулж болно. Тэнцвэрээ хадгалан алхаж чадахгүй тохиолдолд дэмжлэг үзүүлнэ.		
Анхаарах зүйл	Алхаж байхдаа унаж болзошгүй тул орчноо хүүхдэд аюулгүй байхаар бэлтгэнэ. Хүүхэд уур ууцаартай байвал хэсэг хугацаанд тайвширахыг нь хүлээнэ.		

ТУСГАЙ ЦЭЦЭРЛЭГИЙН **ОЮУН УХААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ** ХҮҮХДИЙН ЧАДВАРЫГ ИЛРҮҮЛЭХ
ДААЛГАВАР

Багшийн нэр:
Хүүхдийн нэр:

2024 он ... сар ... өдөр
Бэрхшээлийн онцлог:.....

Даалгаврын дугаар: 9 ОУ-1	Сургалтын чиглэл: Эрүүл мэнд
Илрүүлэх чадвар: Өөртөө үйлчлэх буюу бие дааж гараа угаах Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Хүүхдийн гүйцэтгэлээр	

Даалгавар	Ус гоожуулан гаранд нь саван түрхэж өгөхөд 2 гараа үрж угаана.			
Хэрэглэгдэхүүн	Ариун цэврийн өрөө ,бүлээн ус, шингэн саван, гар угаах угаалтуур			
Даалгаврын заавар	Багшийн хэлсэн зааврын дагуу ариун цэврийн өрөөнд орж гараа угаана.			
Даалгавар явуулах аргачлал	Багшийн хэлэх үг		Багшийн хийх үйлдэл	
	- Хоёулаа гараа угаая. 1. Ханцуйгаа хойш болгоорой. 2. Крантаа нээж усаа гоожуулаарай. 3. Усаар гараа норгоорой. 4. Гар дээрээ савангаа хийгээрэй. 5.Гарын алгаа үрж савангаа хөөсрүүлээрэй. 6. Савангаа арилтал усаар угаагаарай. 7.Крантаа хаагаарай. 8. Өөрийн алчуураар /гарын цаасаар/ гараа арчаарай. - Чи сайн байлаа, чамд баяр хүргэе гээд алга ташна.		Хүүхэд багшийн зааврын дагуу гараа савандаж угааж байгаа үйлдлийг урамшуулна.	
Даалгавар №9 үнэлгээ	№	Хариултын хувилбар		Тохирох тэмдэглэл
	1	Бүх зааврыг бие даан гүйцэтгэсэн.		5
	2	Бие даан 5-6 зааврыг гүйцэтгэсэн.		4
	3	Гараа норгох, хөөсрүүлэх үйлдлүүдийг бие даан гүйцэтгэсэн.		3
	4	Багшийн дэмжлэгтэй гар угаах даалгаврыг хамтран гүйцэтгэсэн.		2
	5	Гараа норгон угаах ородлого хийсэн.		1
	6	Хүүхэд даалгавар гүйцэтгэх оролдлого хийхгүй, татгалзсан.		0
Дэмжлэг	Ус нээх хаах, зохист хэмжээгээр гоожуулахад багш дэмжлэг үзүүлнэ. Зааврыг 1-2 удаа давтан хэлээд хүүхэд биелүүлэх эсэхийг ажиглаад чадахгүй байвал туслаад дараагийн зааврыг хэлж өгнө.			
Анхаарах зүйл	- Ариун цэврийн өрөөний аюулгүй байдлыг хангах. - Үйлдлийг биечлэн хийж үзүүлнэ. - Хүүхэд уур ууцаартай байвал хэсэг хугацаанд тайвширахыг нь хүлээнэ.			

ТУСГАЙ ЦЭЦЭРЛЭГИЙН **ОЮУНЫ БЭРХШЭЭЛТЭЙ** ХҮҮХДИЙН ЧАДВАРЫГ ИЛРҮҮЛЭХ
ДААЛГАВАР

Багшийн нэр:
Хүүхдийн нэр:

2024 он ... сар ... өдөр
Бэрхшээлийн онцлог:.....

Даалгаврын дугаар: 10 ОУ-2			
Сургалтын чиглэл: Бие дааж хийх үйлдэл			
Илрүүлэх чадвар: Өөртөө үйлчлэх буюу бие даах чадвар			
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Хүүхдийн гүйцэтгэлээр			
Даалгаврын сонголт	<ul style="list-style-type: none"> - Гараа угаах - Өмдөө татах - Хоолоо идэх - Тоглоомоо өгөх Тоглоомоо тавь 		
Хэрэглэгдэхүүн	Ангид байгаа тоглоом эд зүйлс, хүүхдийн өөрийн хувцасыг ашиглана.		
Даалгаврын заавар	Дээрх даалгавраас сонгож 3 үйлдлийг хийлгэнэ.		
Даалгавар явуулах аргачлал	Багшийн хэлэх үг		Багшийн хийх үйлдэл
	<ol style="list-style-type: none"> 1. Багш сонгож авсан даалгаврыг гүйцэтгэхтэй холбоотой заавар, команд, зөвлөгөөг оновчтой, тодорхой, хүүхдэд ойлгомжтой давталттай хэлж өгнө. 2. Чи сайн байлаа, чамд баяр хүргэе гээд алга ташна. 		Багш сонгож авсан даалгаврыг хийж үзүүлнэ, хүүхдийг даалгавар гүйцэтгэхэд заавар, командыг тодорхой давтаж хэлж өгнө.
Үнэлгээ	№	Хариултын хувилбар	Тохирох тэмдэглэл
Даалгавар №10 үнэлгээ	1	Бие даан 3 зааврыг гүйцэтгэсэн.	5
	2	Бие даан 2 зааврыг гүйцэтгэсэн.	4
	3	Бие даан 1 зааврыг гүйцэтгэсэн.	3
	4	Багшийн дэмжлэгтэй 1-2 зааврыг гүйцэтгэсэн.	2
	5	Зааврын дагуу даалгавар гүйцэтгэх ородлого хийсэн.	1
	6	Хүүхэд даалгавар гүйцэтгэх оролдлого хийхгүй, татгалзсан.	0
Дэмжлэг	Багш тухайн хүүхдэд тохирсон дэмлэгүүдийг үзүүлнэ. Дэмлэг үзүүлэхдээ хүүхдийн өмнөөс даалгавар гүйцэтгэхгүй харин хүүхдэд өөрөө даалгаврыг гүйцэтгэх талаас нь төрөл бүрийн дэмжлэгийг үзүүлнэ.		
Анхаарах зүйл	Үйлдлийг биечлэн хийж үзүүлнэ. Хүүхэд уур ууцаартай байвал хэсэг хугацаанд тайвширахыг нь хүлээнэ.		

ТУСГАЙ ЦЭЦЭРЛЭГИЙН **ОЮУНЫ БЭРХШЭЭЛТЭЙ** ХҮҮХДИЙН ЧАДВАРЫГ ИЛРҮҮЛЭХ
ДААЛГАВАР

Багшийн нэр:
Хүүхдийн нэр:

2024 он ... сар ... өдөр
Бэрхшээлийн онцлог:.....

Даалгаврын дугаар: 11 ОУ-3			
Сургалтын чиглэл: Бие дааж хийх үйлдэл			
Илрүүлэх чадвар: Өөртөө үйлчлэх буюу бие даах чадвар			
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Хүүхдийн гүйцэтгэлээр			
Даалгаврын сонголт	<ul style="list-style-type: none"> - Ширээ арчих - Алчуур эвхэх - Аягаа зөөх - Ногоо угаах - Цамц эвхэх 		
Хэрэглэгдэхүүн	Ангид байгаа эд зүйлсийг ашиглана.		
Даалгаврын заавар	Дээрх даалгавраас сонгож 3 үйлдлийг хийлгэнэ.		
Даалгавар явуулах аргачлал	Багшийн хэлэх үг		Багшийн хийх үйлдэл
	<ol style="list-style-type: none"> 1. Багш сонгож авсан даалгаврыг гүйцэтгэхтэй холбоотой заавар, команд, зөвлөгөөг оновчтой, тодорхой, хүүхдэд ойлгомжтой давталттай хэлж өгнө. 2. Чи сайн байлаа, чамд баяр хүргэе гээд алга ташна. 		Багш сонгож авсан даалгаврыг хийж үзүүлнэ, хүүхдийг даалгавар гүйцэтгэхэд заавар, командыг тодорхой давтаж хэлж өгнө.
Үнэлгээ	№	Хариултын хувилбар	Тохирох тэмдэглэл
Даалгавар №11 үнэлгээ	1	Бие даан 3 зааврыг гүйцэтгэсэн.	5
	2	Бие даан 2 зааврыг гүйцэтгэсэн.	4
	3	Бие даан 1 зааврыг гүйцэтгэсэн.	3
	4	Багшийн дэмжлэгтэй 1-2 зааврыг гүйцэтгэсэн.	2
	5	Зааврын дагуу даалгавар гүйцэтгэх оролдлого хийсэн.	1
	6	Хүүхэд даалгавар гүйцэтгэх оролдлого хийхгүй, татгалзсан.	0
Дэмжлэг	Багш тухайн хүүхдэд тохирсон дэмлэгүүдийг үзүүлнэ. Дэмлэг үзүүлэхдээ хүүхдийн өмнөөс даалгавар гүйцэтгэхгүй харин хүүхдэд өөрөө даалгаврыг гүйцэтгэх талаас нь төрөл бүрийн дэмжлэгийг үзүүлнэ.		
Анхаарах зүйл	Үйлдлийг биечлэн хийж үзүүлнэ. Хүүхэд уур ууцаартай байвал хэсэг хугацаанд тайвширахыг нь хүлээнэ.		

ТУСГАЙ ЦЭЦЭРЛЭГИЙН **ОЮУНЫ БЭРХШЭЭЛТЭЙ** ХҮҮХДИЙН ЧАДВАРЫГ ИЛРҮҮЛЭХ
ДААЛГАВАР Сонсголд ашиглаж болно.

Багшийн нэр:
Хүүхдийн нэр:

2024 он ... сар ... өдөр
Бэрхшээлийн онцлог:.....

Даалгаврын дугаар: 12 ОУ-4			
Сургалтын чиглэл: Бие дааж хийх үйлдэл			
Илрүүлэх чадвар: Өөртөө үйлчлэх буюу бие даах чадвар			
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Хүүхдийн гүйцэтгэлээр			
Даалгавар	<ul style="list-style-type: none"> - Оймсоо өмсөх - Гутлаа өмсөх - Цамцыг нь барьж өгөхөд гараа хийж өмсөх - Том товч товчлох - Өмдөнд хөлөө хийх, өмсөх оролдлого хийх, оймсоо тайлах оролдлого хийх 		
Хэрэглэгдэхүүн	Ангид байгаа тоглоом эд зүйлс, хүүхдийн өөрийн хувцасыг ашиглана.		
Даалгаврын заавар	Дээрх даалгавраас сонгож 3 үйлдлийг хийлгэнэ.		
	Багшийн хэлэх үг		Багшийн хийх үйлдэл
Даалгаврыг явуулах аргачлал	<p>3. Багш сонгож авсан даалгаврыг гүйцэтгэхтэй холбоотой заавар, команд, зөвлөгөөг оновчтой, тодорхой, хүүхдэд ойлгомжтой давталттай хэлж өгнө.</p> <p>4. Чи сайн байлаа, чамд баяр хүргэе гээд алга ташна.</p>		Багш сонгож авсан даалгаврыг хийж үзүүлнэ, хүүхдийг дуурайлган хийлгэх зэргээр үйлдлийг дэмжиж өгнө. /хүүхэд багшийг дуурайж үйлдэл хийх боломжийг олгоно./
Даалгавар №12 үнэлгээ	№	Хариултын хувилбар	Тохирох тэмдэглэл
	1	Бие даан 3 зааврыг гүйцэтгэсэн.	5
	2	Бие даан 2 зааврыг гүйцэтгэсэн.	4
	3	Бие даан 1 зааврыг гүйцэтгэсэн.	3
	4	Багшийн дэмжлэгтэй 1-2 зааврыг гүйцэтгэсэн.	2
	5	Зааврын дагуу даалгавар гүйцэтгэх оролдлого хийсэн.	1
	6	Хүүхэд даалгавар гүйцэтгэх оролдлого хийхгүй, татгалзсан.	0
Дэмжлэг	Багш тухайн хүүхдэд тохирсон дэмлэгүүдийг үзүүлнэ. Дэмлэг үзүүлэхдээ хүүхдийн өмнөөс даалгавар гүйцэтгэхгүй харин хүүхдэд өөрөө даалгаврыг гүйцэтгэх талаас нь төрөл бүрийн дэмжлэгийг үзүүлнэ.		
Анхаарах зүйл	Үйлдлийг биечлэн хийж үзүүлнэ. Хүүхэд уур ууцаартай байвал хэсэг хугацаанд тайвширахыг нь хүлээнэ.		

ТУСГАЙ ЦЭЦЭРЛЭГИЙН **ОЮУН УХААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ** ХҮҮХДИЙН ЧАДВАРЫГ ИЛРҮҮЛЭХ
ДААЛГАВАР

Багшийн нэр:
Хүүхдийн нэр:

2024 он ... сар ... өдөр
Бэрхшээлийн онцлог:.....

Даалгавар: 13 ОУ-5	Сургалтын чиглэл: Хөдөлгөөн
Илрүүлэх чадвар: Гарын жижиг булчингийн хөгжил	
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Хүүхдийн гүйцэтгэлээр	

Даалгавар	Том шүрийг үдээсэнд сүвлэнэ.		
Хэрэглэгдэхүүн	-Саванд хийсэн 5 ширхэг том шүр, үдээс, аргачлал зураг/ үнэлгээний баг, багш зургийн аргачлалыг бэлтгэнэ.		
Даалгаврын заавар	<ul style="list-style-type: none"> - Багш саванд хийсэн шүрийг нэг нэгээр нь үдээсэнд сүвлэж харуулна. - Багш хайрцагтай шүр, үдээсийг хүүхдэд өгч нэг нэгээр нь сүвлээрэй гэж хэлнэ. /шүр хэлхэх аргачлал/ - Сүвлэсэн шүрийг унагаахгүйн тулд нэг үзүүрийг нь зангидна. - Шүрийг амандаа хийж болохгүй гэдгийг анхааруулна. 		
Даалгаврыг явуулах аргачлал	Багшийн хэлэх үг		Багшийн хийх үйлдэл
	<ol style="list-style-type: none"> 1. Үдээсэнд шүр сүвлэе. 2. Нэг гартаа шүр нөгөө гартаа үдээсээ бариарай. 3. Үдээсний зангилаагүй үзүүрийг шүрний нүх рүү хийгээд гарч ирсэн үзүүрийг бариарай. 4. Үдээсэнд сүвлэсэн шүрийг зангилсан үзүүрт хүргээрэй. 5. Сайн байна дараагийн шүрийг сүвлээрэй. 6. Чи сайн байлаа, чамд баяр хүргэе гээд алга ташна. 		<ul style="list-style-type: none"> - 5 ширхэг том шүр - Богино үдээс - Шүр хийх жижиг сагс - Багш хүүхдэд дэмжлэг үзүүлнэ.
Даалгавар №13 үнэлгээ	№	Хариултын хувилбар	Тохирох тэмдэглэл
	1	4 - 5 шүрийг бие баан үдээсэнд хэлхсэн.	5
	2	2-3 шүрийг бие даан үдээсэнд хэлхсэн	4
	3	Багшийн тусламжтай 3-4 шүрийг үдээсэнд хэлхсэн	3
	4	Багшийн тусламжтай 1-2 шүрийг үдээсэнд хэлхсэн	2
	5	Шүрийг гартаа бариад үдээсэнд хэлхэх оролдлого хийсэн	1
6	Хүүхэд даалгавар гүйцэтгэх оролдлого хийхгүй, татгалзсан бол	0	
Дэмжлэг	Даалгаврыг гүйцэтгэж чадахгүй байгаа хүүхдэд багш эхний нэг шүрийг үдээсэнд сүвлэж харуулна. -Хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхэд даалгавар гүйцэтгэхэд шаардлагатай тохируулга хийж өгнө.		
Анхаарах зүйл	<ul style="list-style-type: none"> - Хүүхдийн аюулгүй байдлыг хангана. \ амандаа хийх\ - 1-2 удаагийн оролдлогоор даалгаврыг гүйцэтгэж чадаагүй тохиолдолд даалгаврыг зогсооно. 		

ТУСГАЙ ЦЭЦЭРЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ЧАДВАРЫГ ИЛРҮҮЛЭХ
ДААЛГАВАР

Багшийн нэр:
Хүүхдийн нэр:

2024 он ... сар ... өдөр
Бэрхшээлийн онцлог:.....

Даалгавар: 14 ХӨ-1	Сургалтын чиглэл: Хөдөлгөөн
Илрүүлэх чадвар: Бөмбөг өнхрүүлэх	
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Хүүхдийн гүйцэтгэлээр	

Даалгавар	Багштай бөмбөгийг харилцан өнхрүүлж /түлхэж/ тоглох.		
Хэрэглэгдэхүүн	Хүүхдийн гаранд баригдахуйц боломжтой бөмбөг сонгоно. / Дунд зэргийн хэмжээтэй бөмбөг/		
Даалгаврын заавар	<ul style="list-style-type: none"> - Багшийн өнхрүүлж өгсөн бөмбөгийг тосч аваад буцаан багш руу харилцан өнхрүүлж 3 удаа тоглоно. - Хүүхэд багшийн хоорондын зай 1 метрээс холгүй байх 		
Даалгаврыг явуулах аргачлал	Багшийн хэлэх үг		Багшийн хийх үйлдэл
	<ol style="list-style-type: none"> 1. Хоёулаа бөмбөг өнхрүүлж тоглоё. 2. Анхааралтай хараарай. 3. Багшийнхаа өнхрүүлсэн бөмбөгийг тосоод аваарай. 3. Барьсан бөмбөгөө багш руугаа буцааж өнхрүүлээрэй. 4. Хоёр гараа урагш сунгаад өнхрүүлсэн бөмбөгийг барьж авахыг сануулна. <p>Багш дасгалын төгсгөлд багштай хамт тоглосон чамд баярлалаа. Чи сайн байлаа, чамд баяр хүргэе гэж хэлээд алга ташна.</p>		<ul style="list-style-type: none"> - Хүүхдийг бөмбөгөөр харилцах бүрт багш алга ташиж урамшуулна. - Хүүхдийн өнхрүүлсэн бөмбөгийг барьж авна.
Даалгавар №14 үнэлгээ	№	Хариултын хувилбар	Тохирох тэмдэглэл
	1	Бусдын тусламжгүй даалгаврыг 3 удаа хийж дуусгасан бол	5
	2	Өнхрүүлсэн бөмбөгийг барьж авч, буцаах үйлдлийг 2 удаа зөв хийж гүйцэтгэсэн бол	4
	3	Өнхрүүлсэн бөмбөгийг барьж авч, буцаах үйлдлийг 1 удаа зөв хийж гүйцэтгэсэн бол	3
	4	Өнхрүүлсэн бөмбөгийг барьж, буцаан өнхрүүлэхийг оролдож байвал	2
	5	Өнхрүүлсэн бөмбөгийг барьж чадаж байвал	1
	6	Хүүхэд даалгавар гүйцэтгэх оролдлого хийхгүй, татгалзсан бол	0
Дэмжлэг	Даалгаврыг эхлүүлэхийн өмнө багш багштай харилцан бөмбөг өнхрүүлж биечлэн хийж үзүүлнэ.		
Анхаарах зүйл	<ul style="list-style-type: none"> - Хүүхэд багшийн хооронд харилцаа үүссэн үед даалгаврыг эхлүүлнэ. - 1 – 2 удаа оролдлого хийгээд хүүхэд огт үйлдэл хийхгүй байвал даалгаврыг цааш үргэлжлүүлэхгүй. - Хүүхэд бухимдал, стресстэй байвал тайвширтал даалгаврыг түр зогсооно. 		

ТУСГАЙ ЦЭЦЭРЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ЧАДВАРЫГ ИЛРҮҮЛЭХ
ДААЛГАВАР

Багшийн нэр:
Хүүхдийн нэр:

2024 он ... сар ... өдөр
Бэрхшээлийн онцлог:.....

Даалгаврын дугаар: 15 ХӨ-2	Сургалтын чиглэл: Танин мэдэхүй
Илрүүлэх чадвар: Тоглоом, эд зүйлийг цувуулж нэг эгнээнд өрөх	
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Хүүхдийн гүйцэтгэлээр	

Даалгавар	6 ширхэгээс доошгүй тоглоом, эд зүйлийг цувуулж нэг эгнээнд өрөх /хоорондоо 20см зайтай зураас, (тууз эсвэл үдээс ашиглан зураас үүсгэнэ) зураасын урт нь сонгож авсан тоглоом, эд зүйлээс хамаарна./
Хэрэглэгдэхүүн	Эвлүүлдэг тоглоом, машин, бөмбөг гэх мэт тухайн хүүхдэд тохирсон 6 ширхэг эд зүйлийг сонгоно. Тууз эсвэл үдээс
Даалгаврын заавар	Зураасны голд тоглоомуудыг нэг эгнээ болгон өрж байрлуулаарай.

Даалгаврыг явуулах аргачлал	Багшийн хэлэх үг	Багшийн хийх үйлдэл
	<ol style="list-style-type: none"> Өмнөө байгаа тоглоомуудаас нэгийг аваарай. Тоглоомоо энэ зураас /бэлтгэсэн зураас шугам байна/ дотор нэг эгнээнд байруулан тавиарай. Одоо тоглоомоос дахиад нэгийг аваад нэг эгнээнд цувуулан байрлуулаарай гэх мэтчилэн цааш үргэлжлүүлнэ. 	<p>- Хүүхдийн өмнө хэрэглэгдэхүүнийг бэлтгэсэн байна.</p> <p>Багш үйлдийг нэг удаа хийж үзүүлнэ.</p> <p>Хүүхдэд даалгаврыг ойлгож биелүүлэх оролдлого байгаа хэдий ч бэрхшээлээс шалтгаалан гар хөлны хөдөлгөөнийг нь дэмжих, чиглүүлэх шаардлагатай бол багш гарыг чиглүүлж өгөх зэргээр дэмжлэгийг үзүүлнэ.</p>

Даалгавар №15 үнэлгээ	№	Хариултын хувилбар	Тохирох тэмдэглэл
		1	6 ширхэг тоглоомыг бие даан нэг эгнээнд өрсөн бол
	2	4-5 ширхэг тоглоомыг бие даан нэг эгнээнд өрсөн бол	4
	3	3 ширхэг тоглоомыг бие даан нэг эгнээнд өрсөн бол	3
	4	1-2 ширхэг тоглоомыг бие даан нэг эгнээнд өрсөн бол	2
	5	Тоглоомыг бариад зураасны ойролцоо байрлуулан тавьсан бол	1
	6	Хүүхэд даалгавар гүйцэтгэх оролдлого хийхгүй, татгалзсан бол	0

Дэмжлэг	Багш хүүхдийн харилцах таатай орчинг бүрдүүлнэ.
Анхаарах зүйл	Бүлгийн багш даалгаврыг гүйцэтгүүлнэ. Хүүхэд бухимдал, стресстэй байвал тайвширтал 5 минут хүлээнэ. Хэт хөдөлгөөнтөх болон хүүхэд босож гүйх гээд байвал буланд ширээг тавьж хүүхдийг суулгаад багш өөрөө өөдөөс нь харж сууна.



ТУСГАЙ ЦЭЦЭРЛЭГИЙН **ХӨДӨЛГӨӨНИЙ БЭРХШЭЭЛТЭЙ** ХҮҮХДИЙН ЧАДВАРЫГ ИЛРҮҮЛЭХ
ДААЛГАВАР

Багшийн нэр:
Хүүхдийн нэр:

2024 он ... сар ... өдөр
Бэрхшээлийн онцлог:.....

Даалгавар: 16 ХӨ-3	Сургалтын чиглэл: Танин мэдэхүй
Илрүүлэх чадвар: Орон зайн баримжаа болон хэлбэр дүрсийг тодорхойлох	
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Хүүхдийн гүйцэтгэлээр	

Даалгавар	Дугуй, дөрвөлжин, гурвалжин, тэгш өнцөгт дүрсүүдийг хэвэнд тохируулан хийнэ.			
Хэрэглэгдэхүүн	Хэв дөрвөн төрлийн дүрс			
Даалгаврын заавар	Багшийн нэрлэсэн дүрсийг 1-1 эер нь авч тохирох хэвэнд нь тохируулан хийнэ.			
Даалгавар явуулах аргачлал	Бүлгийн багшийн хэлэх үг		Бүлгийн багшийн хийх үйлдэл	
	<ul style="list-style-type: none"> - Урдаа байгаа дүрснүүдээс дугуй дүрсийг багшдаа авч үзүүлээрэй. - Сайн байна одоо дугуй дүрсээ тохирох хэвэнд нь тааруулж хийгээрэй. - Сайн байна одоо дөрвөлжин дүрсийг багшдаа авч үзүүлээрэй гэх мэтчилэн үргэлжлүүлнэ. - Чи сайн байлаа, чамд баяр хүргэе гээд алга ташна. 		Багш хавтгай болон дугуй, дөрвөлжин, гурвалжин, тэгш өнцөгт дүрсийг ширээн дээр байрлуулна.	
Даалгавар №16 үнэлгээ	№	Хариултын хувилбар		Тохирох тэмдэглэл
	1	Нэрлэсэн 4 дүрсийг зөв сонгон авч, тохирох хэвэнд зөв байрлуулсан		5
	2	Нэрлэсэн 3 дүрсийг зөв сонгон авч, тохирох хэвэнд зөв байрлуулсан		4
	3	Нэрлэсэн 2 дүрсийг зөв сонгон авч, тохирох хэвэнд зөв байрлуулсан		3
	4	Нэрлэсэн 1 дүрсийг зөв сонгон авч, тохирох хэвэнд зөв байрлуулсан		2
	5	Нэрлэсэн дүрсийг зөв сонгоогүй боловч дүрсүүдийг хараад тохирох хэвэнд зөв байрлуулсан.		1
	6	Хүүхэд даалгавар гүйцэтгэх оролдлого хийхгүй, татгалзсан бол		0
Дэмжлэг	Үйлдлийг зөв хийж байгаа ч гарын жижиг булчин сайн хөгжөөгүй тохиолдолд багш дэмжлэг үзүүлж болно.			
Анхаарах зүйл	Бүлгийн багш болон хүүхдийн таньдаг багш байх Хүүхдийн анхаарлыг сарниулахгүй орчин бүрдүүлнэ. Даалгаврыг 1-2 удаа эхлүүлээд хийхгүй байгаа тохиолдолд даалгаврыг зогсооно.			

ТУСГАЙ ЦЭЦЭРЛЭГИЙН **ХӨДӨЛГӨӨНИЙ БЭРХШЭЭЛТЭЙ** ХҮҮХДИЙН ЧАДВАРЫГ ИЛРҮҮЛЭХ
ДААЛГАВАР

Багшийн нэр:
Хүүхдийн нэр:


2024 он ... сар ... өдөр
Бэрхшээлийн онцлог:.....


Даалгавар: 17 ХӨ-4	Сургалтын чиглэл: Танин мэдэхүй
Илрүүлэх чадвар: Орон зайн баримжаа болон хэлбэр дүрсийг тодорхойлох	
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Хүүхдийн гүйцэтгэлээр	


Даалгавар	Зураасны хэв, хэлбэрт тохируулан жижиг зүйлсийг давхарлаж өрнө.		
Хэрэглэгдэхүүн	4 өөр зураастай цаас бэлтгэнэ. Том хэмжээтэй товч эсвэл жижиг чулуу /хэдэн см-ын хэмжээтэй/		
Даалгаврын заавар	Цаасан дээр байгаа зураасны дагуу чулууг тохируулан өрнө. Чулууг (товч, шагай байж болно) амандаа хийж болохгүйг анхааруулна.		
Даалгавар явуулах аргачлал	Бүлгийн багшийн хэлэх үг		Бүлгийн багшийн хийх үйлдэл
	Цаасан дээр байгаа зураасыг сайн ажиглаарай. - Багш нь чамд эхлээд хийж үзүүлье - Чулуунаас (товч) нэг нэг ширхэгээр авч зураасны дагуу байрлуулна. - Дөрвөн өөр зураасыг тус бүр хийж гүйцэтгээрэй. - Чи сайн байлаа, чамд баяр хүргэе гээд алга ташна.		Багш 1-2 зураасын дагуу хэрхэн өрж байрлуулахыг биечлэн үзүүлнэ. Хүүхдийн аюулгүй байдалд анхаарна.
Даалгавар №17 үнэлгээ	№	Хариултын хувилбар	Тохирох тэмдэглэл
	1	Чулууг бие даан 4 зураасын дагуу жигд нямбай байрлуулж өрсөн бол	5
	2	Чулууг бие даан 2-3 зураасын дагуу жигд нямбай байрлуулж өрсөн бол	4
	3	Чулууг бие даан 1 зураасын дагуу жигд нямбай байрлуулж өрсөн бол	3
	4	Багшийн тусламжтай 1 зураасын дагуу өрсөн бол	2
	5	Чулуунаас аваад зураасны ойролцоо байрлуулах оролдлого хийсэн бол	1
	6	Хүүхэд даалгавар гүйцэтгэх оролдлого хийхгүй, татгалзсан бол	0
Дэмжлэг	Үйлдлийг зөв хийж байгаа ч гарын жижиг булчин сайн хөгжөөгүй тохиолдолд багш дэмжлэг үзүүлж болно.		
Анхаарах зүйл	Бүлгийн багш болон хүүхдийн таньдаг багш байх Хүүхдийн анхаарлыг сарниулахгүй орчин бүрдүүлнэ. Даалгаврыг 1-2 удаа эхлүүлээд хийхгүй байгаа тохиолдолд даалгаврыг зогсооно. Хүүхдийн аюулгүй байдалд анхаарч ажиллана.		




Даалгавар №17 хэрэглэгдэхүүн









Даалгавр№ 18, 19, 20-д ашиглана.

ТУСГАЙ ЦЭЦЭРЛЭГИЙН **ХӨДӨЛГӨӨНИЙ БЭРХШЭЭЛТЭЙ** ХҮҮХДИЙН ЧАДВАРЫГ ИЛРҮҮЛЭХ
ДААЛГАВАР

“Манжин” (орос ардын үлгэр)

Эрт урьд цагт нэгэн өвгөн манжин тарьжээ. Гэтэл өнөөх манжин томоос том ургажээ. Нэг өдөр өвгөн манжингаа хураахаар талбайдаа ирээд манжингаа татаад татаад сугалж чадсангүй. Татаад л байж, татаад л байж дийлдэггүй гэнэ. Тэгээд эмгэнээ дуудлаа.

Эмгэн, эмгэн наашаа ирээч ямар том манжин бэ? гэхэд эмгэн ч ирж өвгөнөөсөө, харин өвгөн манжингаасаа татав. Бас л дийлсэнгүй. Эмгэн ач охиноо дуудлаа.

Ач охин, ач охин наашаа ирээч, ямар том манжин бэ? гэхэд ач охин ирж эмгэнээс, эмгэн өвгөнөөс харин өвгөн манжингаасаа татаад л байж, мөн л дийлсэнгүй. Охин нохойгоо дуудав.

Нохой, нохой наашаа ирээч, ямар том манжин бэ? гэхэд нохой ч тэр даруй л хүрээд ирэв.

Нохой охиноос, охин эмгэнээс, эмгэн өвгөнөөс, өвгөн манжингаасаа татав. Хэчнээн татсан ч дийлсэнгүй тул муураа дуудав. Муур ч ирэн нохойноос, нохой охиноос, охин эмээгээсээ, эмгэн өвгөнөөсөө, өвгөн манжингаасаа татав. Гэсэн ч дийлсэнгүй. Муур хулганаа дуудлаа. Хулгана муураас, муур нохойноос, нохой ач охиноос, охин эмээгээс, эмээ өвгөнөөс, өвгөн манжингаас татаад л байж, татаад л байж, манжин сугаран гарав.

ТУСГАЙ ЦЭЦЭРЛЭГИЙН **ХӨДӨЛГӨӨНИЙ БЭРХШЭЭЛТЭЙ** ХҮҮХДИЙН ЧАДВАРЫГ ИЛРҮҮЛЭХ
ДААЛГАВАР

Багшийн нэр:
Хүүхдийн нэр:

2024 он ... сар ... өдөр
Бэрхшээлийн онцлог:.....

Даалгавар: 18, 19, 20ХӨ-5, ХӨ-6	Сургалтын чиглэл: Танин мэдэхүй
Илрүүлэх чадвар: - Орчны дуу чимээг сонсох, дуурайх - Орчны ургамал, амьтныг сонирхох, нэрлэх - Үйл явдлын дарааллыг олж байрлуулах - Тоолоод дүн тоог хэлэх	
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Хүүхдийн гүйцэтгэлээр	

Даалгавар	Асуултад хариулаарай.			
Хэрэглэгдэхүүн	“Манжин” үлгэрийн бүх дүрүүд Дүн тоо			
Даалгаврын заавар	Багш хүүхдэд “Манжин” үлгэрийг уншиж өгөөд асуулт асууж ярилцана.			
Хэл яриа Даалгавар явуулах аргачлал	Бүлгийн багшийн хэлэх үг		Бүлгийн багшийн хийх үйлдэл	
	Багш “Манжин” үлгэрийн бүх дүрүүдийг өгөгдсөн зурагт картын дагуу бэлтгэн хүүхдийн өмнө байрлуулах ба дараах даалгаврыг гүйцэтгүүлнэ. Асуулт : 1. “Энэ ямар хүнсний ногоо вэ?” (Манжин) 2. Үлгэрт хэн манжинг тарьсан бэ? (Өвгөн манжин тарьсан) гэж 3. Өвгөн хэнийг дуудсан бэ? (Өвгөн эмгэнийг дуудсан) 4. Үлгэрт хав, хав хав гэж дуугардаг амьтан гарсан. Энэ ямар амьтан бэ? Нэрийг хэлээрэй. (Нохой) 5. Үлгэрт “мяу, мяу, мяу” гэж дуугардаг амьтан гарсан. Энэ ямар амьтан бэ? Нэрийг хэлээрэй. (Муур)		Хүүхдийн хариултыг анхааралтай сонсоно.	
Даалгавар №18 үнэлгээ	№	Хариултын хувилбар		Тохирох тэмдэглэл
	1	5 асуултад зөв хариулсан бол		5
	2	4 асуултад зөв хариулсан бол		4
	3	3 асуултад зөв хариулсан бол		3
	4	2 асуултад зөв хариулсан бол		2
	5	1 асуултад зөв хариулсан бол		1
6	Хүүхэд даалгавар гүйцэтгэх оролдлого хийхгүй, татгалзсан бол		0	
Хэл яриа Даалгавар явуулах аргачлал	Бүлгийн багшийн хэлэх үг		Бүлгийн багшийн хийх үйлдэл	
	Багш хүүхдийн урд үлгэрийн дүрүүдийн зурагт картын тарааж өгөөд үлгэрийн дүрүүдийг дарааллын дагуу байрлуулж өрөөрэй гэсэн даалгавар өгнө.		Зурагт картыг хүүхдийн урд хольж тавьна.	
Даалгавар №19 үнэлгээ	№	Хариултын хувилбар		Тохирох тэмдэглэл
	1	5-6 дүрийг зөв дарааллаар байрлуулсан бол		5
	2	3-4 дүрийг зөв дарааллаар байрлуулсан бол		4
	3	1-2 дүрийг зөв дарааллаар байрлуулсан бол		3
	4	Багшийн тусламжтай 1-2 дүрийг эгнүүлэн тавьсан бол		2
5	Дүрийг дарааллаар байрлуулах оролдлого хийсэн бол		1	

ТУСГАЙ БҮЛЭГ “БҮЛГИЙН БАГШ” -ҮНЭЛГЭЭНИЙ БАГИЙН АШИГЛАХ ХУВИЛБАР

	6	Хүүхэд даалгавар гүйцэтгэх оролдлого хийхгүй, татгалзсан бол	0
Математикийн энгийн төсөөлөл Даалгавар явуулах аргачлал	Бүлгийн багшийн хэлэх үг		Бүлгийн багшийн хийх үйлдэл
	1. Манжин үлгэрт хэдэн өвгөн гарсан бэ? 2. Манжин үлгэрт хэдэн эмгэн гарсан бэ? 3. Манжин үлгэрт хэдэн охин гарсан бэ? 4. Манжин үлгэрт хэдэн амьтан гарсан бэ? 5. Үлгэрт нийт хэдэн дүр гарсан бэ? тоолоод дүн тоог хэлээрэй.		1. Өвөө, эмээ, ач охины 3 хүний зургийг хүүхдийн урд эгнүүлэн тавина. 2. Нохой, муур, хулгана 3 амьтны зургийг хүүхдийн урд эгнүүлэн тавина. 3. Үлгэрийн бүх дүрийн зургийг хүүхдийн урд эгнүүлэн тавина.
Даалгавар №20 үнэлгээ	№	Хариултын хувилбар	Тохирох тэмдэглэл
	1	5 асуултад зөв хариулсан.	5
	2	4 асуултад зөв хариулсан.	4
	3	3 асуултад зөв хариулсан.	3
	4	2 асуултад зөв хариулсан.	2
	5	Үг хэлж, үйлдэл үзүүлж асуултад хариулахыг оролдсон бол	1
	6	Хүүхэд даалгавар гүйцэтгэх оролдлого хийхгүй, татгалзсан бол	0
Дэмжлэг	Багш асуултыг асуусны дараа хүүхэд хариулахгүй бол дотроо 5 секунд тоолоод дахин нэг удаа асууна. Энэ мэтчилэн багш асуултыг 3 удаа л асууна. Мөн багш амьтдын дуу авиаг биечлэн хийж үзүүлнэ. Хэрвээ хүүхэд хариулахгүй бол дотроо 5 секунд тоолоод дахин нэг удаа дуугарч үзүүлнэ. Хүүхэд хариулахгүй бол даалгаврыг гүйцэтгэж чадаагүйд тооцож оноог өгнө.		
Анхаарах зүйл	Хүүхэд энэхүү даалгавар гүйцэтгэх явцад сургалтын 2 чиглэлийн чадварыг илрүүлэх тул хөндлөнгөөс үнэлгээ өгч буй гишүүн анхааралтай хандах хэрэгтэй.		

